



ХЭНГИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 1/26

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59.1.23 дахь хэсэг, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/07 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон сууцны барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч.	Э.Балчиндорж	Засаг даргын орлогч
Гишүүд:	Ө.Өнөрөө	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Г.Загдхорол	Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/07 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулахыг ажлын хэсгийн нийт гишүүдэд даалгасугай.

3.Удирдлага зохион байгуулалтаар хангаж, захирамжийн хэрэгжилтийг илтгэх хуудсаар мэдэгдэхийг Засаг даргын орлогч (Э.Балчиндорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР